

Мега төсөл хэрэгжихид нөлөөлөх улс төрийн хүчин зүйлс, түүнд хийх анализ

Докторант: Б.Нандин-Эрдэнэ (Улс төр судлалын докторант)

Хураангуй:

Хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын хувьд хөрөнгө оруулалт нь эдийн засгийг хөгжүүлэх чухал тулгуур¹ болдог тухай эдийн засагчид, бодлого боловсруулагчид, судлаачид үзсэн байдаг. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр дотоод, гадаад эх үүсвэрээс бүрддэг. Хөгжиж буй болон Монгол шиг жижиг эдийн засагтай, мөнгөн хуримтлалын суурь дутмаг орнуудын хувьд гадаад хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь эдийн засгийг идэвхижүүлэх, өсгөхөд чухал нөлөөтэй хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл гадаадын хөрөнгө оруулалт нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн суурийг өргөжүүлэх, жижиг дунд бизнесүүдийн боломжийг нэмэх, ажил эрхлэлтийг урамшуулах зэрэг эерэг нөлөөтэй байдаг². ГХО-д маш том байр эзэлдэг хөрөнгө оруулалт бол Мега төсөл юм. Манай улсад болон бусад хөгжиж буй улсын хувьд Мега төсөл ГХО-ын шугамаар орж ирдэг. Мега төсөл бол ГХО-ын урсгалыг нэмэгдүүлэх, дотоодын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх эерэг олон хандлагатай. Мега төсөл улс орны эдийн засгийн хөгжлийг дараагийн түвшинд шилжихэд туслах нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй төсөл учраас түүнийг хэрэгжихэд нөлөөлөх улс төрийн хүчин зүйлсийг судлах нь улс төрийн эдийн засгийн шинжлэх ухааны зайлшгүй судлах судлагдахуун юм.

Түлхүүр үг: мега төсөл, улс төр, улс төрийн институц, хууль тогтоомж

Аливаа улсын хурдацтай, эрчимтэй хөгжих процест Мега төсөл маш том байр суурь эзэлдэг олон улсын жишээ байдаг. Монгол улсын ГХО 2010-2012 онуудад эрчимтэй өсч эдийн засгийн өндөр өсөлттэй байсан бол өнөөдрийн байдлаар ГХО орж ирэх нь эрчимтэй буурч эдийн засгийн хүндрэлтэй буюу хямралтай байдалд орсон энэ үед эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн

¹ Carsten Hefeker Political Risk, Institutions and Foreign Direct Investment 2005

² Markusen (1995)

засгийн үр өгөөжийг дараагийн түвшинд авчрах бодлого боловсруулж, тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэх цаг бидний өмнө тулгамдаад байгаа. Энэхүү эдийн засгийн хямралтай байдлаас гарах нэг зайлшгүй гарц бол Мега төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна. Мега төсөл нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилтэй шууд холбогдох учраас түүнийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх улс төрийн хүчин зүйлсийг тодруулах, эерэг болон сөрөг нөлөөлөх улс төрийн хүчин зүйлсийг ил болгож түүнд анализ хийх нь нийгмийн амьдралын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг бий болгох, дотооддоо бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, олон улсын түвшинд өрсөлдөх гэх мэт улс төр, эдийн засаг, нийгмийн өгөөжтэй асуудал болж байна. Эдийн засгийн өндөр хөгжил улс төрийн төлөвшлийг бий болгохгүй, харин зохистой улс төрийн төлөвшил, улс төрийн бодлого эдийн засгийн хөгжлийг хурдасгана. Мега төсөл бол энгийн нэг төсөл биш, харин түүний үр дүн нь нийгмийн хөгжилд асар их дэвшил, боломжийг бий болгох төсөл юм. Мега төслийн ойлголт нь 1970-иад оны эхэн үед Канадын Засгийн газар болон АНУ-н Бектел контрактор байгууллагын хоорондын том хэмжээний төслийн гэрээнээс үүссэн³. Энэхүү ойлголтоос өмнө том хэмжээний Египтийн пирамид, Мексик дахь Маяачуудын хот, Ромын эзэнд гүрэн гэх мэт бүтээн байгуулалтууд дэлхийн улсуудад аль хэдийн бий болсон байсан. “Мега” гэдэг үг нь Грек хэлний “мега” гэх үгнээс гаралтай бөгөөд хэл зүйн хувьд үгний угтвар, үндэс нь болдог. Оксфордын Ахисан түвшний суралцагчдын толь бичигт энэ үгийг тайлбарлахдаа маш том, агуу⁴ гэсэн утгыг илэрхийлсэн байдаг. Мөн том, маш том, бүрэн гүйцэт, өргөн уудам гэсэн утгуудыг илэрхийлдэг байна. Мега гэдэг үг нь төсөл гэдэг үгтэй холбогдоод мега төсөл гэдэг нь маш том хэмжээний, материаллаг, нийгэмд үзүүлэх үр ашиг нь өндөр (их хэмжээний) төслийг онцолсон байдаг. Мөн Collins толь бичигт маш том, үнэ цэнтэй, томоохон бизнесийн төсөл гэж тайлбарласан.

2000 оноос хойш Мега төсөл гэдэг үг, судалгааны ажил маш их өргөн тархах болсон. Мега төслийн талаарх ойлголтыг иргэдэд түгээхэд гол нөлөө үзүүлсэн “Глобалчлал ба Хотын өөрчлөлт: Капитал (хөрөнгө), Соёл ба Номхон далайн

3 Alfons van Marrewijk, Organizing Mega-projects: Understanding their Cultural Practices, in 2012, Netherland

4 http://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/mega_1?q=mega

эргийн Мега төслүүд”, “Мега төсөл: Хотын улсын хөрөнгө оруулалтын өөрчлөгдөж буй Улс төр”, “Мега төсөл ба Эрсдэл: Амбицийн анатоми” гэх 3 ном байдаг. Мөн олон судалгааны ажил, бүтээлд Мега төслийн талаарх асуудлыг хөндөн, олон талаас, олон хандлагаар судалсан байдаг. Эдгээр хандлагуудыг нэгтгэн 3 төрөлд хуваан үзэж болно. Эхнийх нь, төслийг пропорти буюу хөрөнгөөр нь авч үзэх хандлага. Мега төсөл бол бүтээн байгуулалтын төсөл. Гэвч түүний хөрөнгө оруулалт, хэмжээ, үүрэг зэргээс хамаараад ердийн/энгийн төсөл болох тохиолдол байдаг. Төслийн үр дүн хэрэгжилтийн харьцааг тооцох, эдийн засгийн үр өгөөжийг хамгийн дээд цэгт байлгах тал дээр үргэлж анхаарч шийдвэр гаргахыг зорьдог. Судлаач Мерроу 52 Мега төслийн санхүүжилтийг судлаад дундаж хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2 тэрбум доллар буюу 2 их наяд төгрөг (1984 оны байдлаарх тоон хэмжээ) байгааг харуулсан. Судлаач Хүго Мега төсөл техник технологийн шинэ дэвшилтэт бүтээгдэхүүнийг бий болгож инновацийг дэмждэг тухай судалсан байна. Дараах хандлага нь глобалчлал болон соёл иргэншлийн хоорондын харилцааны асуудлыг судалсан. Судлаач Олд глобалчлал болон соёл иргэншилд Мега төслийн эзлэх байр суурь өсөн нэмэгдэж буйг судалж глобалчлалын суурь болж буйг харуулсан. Сүүлийн хандлага бол Мега төсөл улс төрийн оролцоонд нөлөөлөх хандлагыг судалсан. Эрдэмтэн Алтшулер, Луберофф нар орчин үеийн Мега төслийг хөрөнгө оруулалт дахь улс төрийн өөрчлөлттэй холбон судалсан байдаг. Ванг, Занг нар Мега төсөлд улс төр, эдийн засаг, нийгмийн нөлөө хэрхэн тусч болохыг судалсан байдаг⁵. Мега төсөл⁶ гэдгийг

5 Guangshe Jia, Fangjung Yang et al, A study of mega project from a perspective of social conflict theory, International Journal of Project Management, in 2011, 818pp.

6 Мега төслийн гол шинжүүд: Хөрөнгө оруулалт нь 1 тэрбум доллар /2 их наяд төгрөг/- аас их хэмжээтэй; Хамтрагч (хувьцаа эзэмшигч), оролцогчдын тоо их; Эзэмшигч нь ЗГ эсвэл Хувийн сектор байдаг; Маш олон төрлийн гэрээ, хууль зүйн тогтоомж шаардлагатай; Улс төрийн нөлөөлөлд өртөмхий; Хэрэгжүүлэхэд нарийн төвөгтэй; Өргөн цар хүрээ бүхий, газар нутгийн хувьд тархсан, алслагдсан; Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөлөл их; Иргэд, олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй; Цаг хугацааны хувьд урт удаан хугацаанд хэрэгждэг; Удаан хугацаанд хэрэгждэг тул улс төрийн шийдвэр гаргалтын нөлөөлөл их; Шинэ болон батлагдаагүй технологи, хууль тогтоомжтой тулгардаг; Шинэ болон батлагдаагүй технологи, хууль тогтоомжтой тулгардаг; Улс орны хэмжээний асуудал хөндөгддөг; Тодорхой бус байдал өндөр (зах зээлийн, технологийн, улс төрийн г.м); Тусгай зөвшөөрөл авахад хүндрэлтэй; Шаардлагатай хүний нөөцийн чадавхи сул хөгжсөн гэх мэт.

тоймлон авч үзвэл улс орны эдийн засгийн хөгжил⁷-д ахиц авч ирэх, өнөөгийн байгаа эдийн засгийн хөгжлийн түвшинг дараагийн түвшинд шилжихэд туслах нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй төслийг ойлгож болно.

Манай улсын эдийн засгийн өсөлт ГХО-аас шууд хамааралтай гэж болно. ГХО-ын дийлэнх хувь нь зөвхөн уул уурхайн салбарт ордог, тэр дотроо дан ганц “Оюутолгой” төслөөс шууд хамаарч байсан учраас манай эдийн засаг ганц салбараас хамаарсан, эмзэг бүтэцтэй хэвээр байна. 2009.10.06-нд үзэглэгдэж, 2013 оны 8 сард түр зогсох хүртлээ “Оюутолгой” төслийн хөрөнгө оруулалт эрчимтэйгээр хийгдэж байсан гэж үзвэл төсөлд оруулсан 7 гаран тэрбум долларын хөрөнгө оруулалт нь 2010-2013 онд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 54%-ыг, уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын 85%-ыг бүрдүүлсэн байна. Түүнчлэн “Оюутолгой” төслийн нийт борлуулалт 2 тэрбум доллар байхад нэрлэсэн ДНБ 11,5 тэрбум доллар байгаа нь манай улсын жилийн нийт үйлдвэрлэлийн 17% нь зөвхөн “Оюутолгой” төслөөс хамаарч байгааг илтгэнэ. Үүнээс харахад ГХО-д Мега төсөл томоохон байр суурь эзэлдэг болох нь харагдаж байна. Манай улсын нийт ГХО-ын томоохон хувийг Мега төсөл эзэлж байна. Энэ төслүүдэд Оюутолгой, Тавантолгой, “Цахилгаан Станц-5”, “Эрдэнэт”, “Хуучны-Орос барилгууд”, “Эгийн голын цахилгаан станц” гэх мэт нийгэм, эдийн засгийн хөгжилд асар их хувь нэмэр оруулсан төслийг багтаасан болно.

Мега төсөл нь цогц төсөл учраас түүний ашиглалт, санхүүжилт, төр болон хувийн хэвшлийн хослол, хамтралыг нарийн тусгаж өгсөн байдаг. Шинэ үеийн мега төслүүд ихэвчлэн төрийн оролцоотойгоор хувийн хэвшлийн ашиг сонирхлыг харгалзан хамтарч хийдэг хандлага бий болсон⁸. Судлаач Moulaert, Rodriguiz, Swygedouw нарын 2003 оны судалгаагаар Европын холбооны улсуудын хотын хөгжлийн талаарх 13 мега төслийн 12 нь төрийн удирдлагын дор эсвэл төрөөс санхүүжиж, гэрээний дагуу төр хувийн хэвшлийн хамтарсан (PPP) байдлаар үйл ажиллагаагаа явуулж төр болон хувийн хэвшлийн хооронд бүтцийн хамтын ажиллагаа явагдаж тодорхой үр дүнд хүрдэг байна. Энэ нь мега төсөл төр, улс

⁷ Эдийн засгийн хөгжил гэдгийг GDP буюу ДНБ-ээр илэрхийлэгдэх эдийн засгийн өсөлтийг ойлгож байгаа.

⁸ Ute Lehrer, Jennefer Laidly, Old Mega-Projects Newly packaged? Waterfront Redevelopment in Toronto, in 2008, International Journal of Urban and Regional Research, vol.32

төртэй ямар нэгэн хэлбэрээр холбогддог болох нь харагдаж байна. Улс төр Мега төсөлтэй холбогдох олон хүчин зүйл байдгийн нэг нь хууль байдаг. Манай улсын хувьд Хөрөнгө Оруулалтын тухай хуулийн 5-р бүлэг 20.1-д Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гэж заасан нь томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг төр өөртэйгээ хамааралтай болгож байна.

Мөн Мега төсөл улс төрийн хүчин зүйлстэй холбогддог дараагийн нэг зүйл нь улс төрийн нам, намын доторхи фракц, хувь улс төрчийн ашиг сонирхол юм. Монгол улсын төрийн аппаратыг бүрдүүлж байгаа гол хүчин бол улс төрийн нам. Улс төрийн намыг намын номенклатурууд, улс төрийн фракц, бүлэглэлүүд удирддаг. Улс төрийн бүлэглэл, фракцыг цөөн тооны улс төрчид удирддаг. Сонгуульд ялсан намын мөрийн хөтөлбөр улс орны хөгжлийн бодлого болон хэрэгждэг. Энэ хамаарлаас харахад төр, улс төр хоёрыг монголын жишээн дээр ялган үзэхэд бэрх юм. Төр нэрийн дор улс төрийн цөөн бүлэглэлүүд оршиж, түүний ард тэдгээр бүлэглэлүүдийн тэмцэл өрнөж байна гэж харахаар байна. Эдгээр улс төрийн хүчин зүйлүүдийн талаар Могол улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн гуай хэлэхдээ: "...Гадны хөрөнгө оруулагч гэдэг тохиолдлын хүмүүс, тэд Монголын боловсруулах үйлдвэр юм уу, багаж хэрэгслийн үйлдвэрт хөрөнгө хийгээгүй шүү дээ. Ердөө л Монголын уул уурхайг сонирхож, баялгийг нь цөлмөх гэж ирж байгаа. Тэдний хахуулиар амьдардаг, тэдэнд үйлчилдэг түшмэдийн бүлэг Монголд бий болсон нь бодит аюул. Хоёрдугаарт, гадны хөрөнгө оруулагчдад үйлчилж, тэдний гарыг долоож амь зогоодог, хаялгыг нь авч амьдардаг компаниуд, үйлчлэгчид бий болжээ. Гуравдугаарт, гадны хөрөнгө оруулагчдын Монгол дахь бие төлөөлөгч болж, тэдний өмнөөс ухуулга хийдэг, эрх ашгийг нь хамгаалдаг лобби бүлэг, төрийн бус байгууллага хүртэл бий болоод байна. Дөрөвдүгээрт, тэдний захиалгаар Монголд хууль гаргадаг, тэдний төлөө Их хурлын гишүүнийхээ товчийг дардаг, тэдэнд үйлчилж хуулийн төсөл хийдэг төрийн түшээд бөөн бөөнөөрөө байна. Ийм замаар явж бид хямралаас гарахгүй⁹" гэсэн. Олон судлаач, улс төрчид, эдийн засагчид ГХО, Мега төслийн хэрэгжилтэд улс төрийн хүчин зүйлс, түүн

⁹ News.gogo.mn/r/173307

дотроо улс төрийн институц нөлөөлдөг гэх боловч үүнийг судалгаагаар баталсан эрдэмтэн, судлаачид цөөхөн байна. Улс төрийн ямар хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг тодруулах нь цаашдын ГХО, Мега төслийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй. Тийм учраас энэ асуудлын хүрээнд оновчтой үр дүнд хүрэхийн тулд судалгаа хийсэн болно.

Улс төрийн хүчин зүйлс Мега төслийн хэрэгжилт¹⁰-д хэрхэн нөлөөлж буйг тодруулж түүнд анализ хийн шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь энэхүү судалгааны гол зорилго мөн. Улс төрийн хүчин зүйлст судалгааны хүрээнд улс төрийн институц, ардчилал, авлигал, хүнд суртал, дотоод, гадаад зөрчил зэргийг багтаан авч үзсэн. Улс төрийн институц гэдэг улс төрийн байгууллага, улс төрийн соёл, түүх, улс төрийн философи, улс төрийн ухамсар зэрэг олон ойлголтууд багтдаг. Энэ судалгааны хүрээнд улс төрийн институцид улс төрийн байгууллагыг авч үзсэн. Харин Мега төслийг ГХО-аар төлөөлүүлэн авч үзсэн. Учир нь хөгжиж буй улсын хувьд Мега төсөл ГХО-ын шугамаар эх үүсвэр нь олгогдож хэрэгждэг. Энэ талаар судалсан гадаадын олон эрдэмтэн, судлаачид байдаг. Харин манай улсын судлаачдын хувьд энэ талаар судалсан судалгааны ажил хараахан байхгүй байна.

Олон улсын түвшинд Гадаадын Хөрөнгө оруулалт, Мега төслийн хөгжилд улс төрийн институцийн нөлөөллийг тогтоох улс төрийн шинжлэх ухааны судалгаанууд өргөнөөр хийгдсэн байдаг. Тухайлбал Basi (1963) Улс төрийн тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтанд хэрхэн нөлөөлж буйг судласан цагаас хойш олон арван судалгааны ажлууд бичигдсэн байна. Тэдгээр судалгаанууд нь улс төрийн институцийн хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Мега төслийг хэрэгжүүлэхэд суурь хүчин зүйлс болж буй эсэх, ялангуяа ямар институцийн чанарын үзүүлэлт хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэйг судлахад чиглэгдсэн байдаг. Эдгээр ажлуудыг багцлан шинжилж үзэхэд үндсэн 3-н хэсэгт хувааж болно. Үүнд: 1) North (1990) –н судалгаанд суурилсан судалгаанууд буюу Улс төрийн институци нь хөрөнгө оруулалт болон эдийн засгийн хөгжлийг

¹⁰ Мега төслийн хэрэгжилт гэх ойлголтод Мега төслийн шийдвэр гаргахаас авахуулаад төслийн үйл ажиллагаа явуулах бүх үйл явцыг багтаан үзнэ.

урамшуулах суурь үзүүлэлт болохыг харуулсан тухай 2) 1990 оноос эхлэсэн шилжилтийн болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын хурдтай хөгжилд татагдсан Гадаадын Хөрөнгө Оруулалтын урсгал буюу Зөвлөлт системд багтаж байсан шилжилтийн эдийн засагтай ОХУ, Казакстан, Польш болон Зүүн Азийн хөгжиж буй эдийн засагтай улс орнууд болох Хятад, Өмнөд Солонгос, Малайз, Сингапур, Тайланд гэх мэт орнуудыг чиглэсэн хөрөнгө оруулалтын томоохон урсгалын талаар судалсан судалгааны ажлууд 3) (Bevan ба бусад 2004) судалсан гадаадын хөрөнгө оруулагч нарын улс төрийн институцийн чанарт суурилсан хөрөнгө оруулалт хийх тухай судалгаанууд байдаг.

Олон улсын байгууллагууд болон томоохон бодлого тодорхойлогчид улс төрийн сайн засаглал нь Гадаадын хөрөнгө оруулалтыг татах суурь үзүүлэлт болдог гэж батладаг¹¹. Гэвч сүүлийн үеийн судалгаануудын үр дүнгээс үзэхэд улс төрийн институцийн чанарын үзүүлэлтүүд нь Гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулдаг гэсэн баттай нотолгоо хийгдээгүй байна¹². Тухайлбал Lim (2001) 75 орныг хамруулсан эмпирек судалгаандаа улс орнуудын хувьд харилцан адилгүй нөлөөлөлтэйг харуулсан бөгөөд хөрөнгө оруулалтын зохицуулалт, хүнд суртал болон шүүхийн ил тод байдал зэрэг үзүүлэлтүүд нь улс төрийн эрсдэлээс бага нөлөөлөлтэйг харуулсан. Blonigen (2005) судалгаандаа зарим улс төрийн институцийн хүчин зүйлс нь эерэг нөлөөтэй, зарим үзүүлэлтүүд нь сөрөг нөлөөтэй байж болно гэж дүгнэсэн. Эдгээр хоёр судлаачийн бүтээлүүдийг нь аргазүйн болон хэмжсэн суурь үзүүлэлтүүдийн хувьд аргазүйн хувьд дутагдалтай байсан гэж Norbert Fiess (2008) дүгнэсэн байдаг.

Globerman болон Shapiro (2002), Busse болон Hefeker (2005), Benassy-Quere бусад (2005) нарын судалсан судалгаануудын үр дүнд улс төрийн институци болон гадаадын хөрөнгө оруулалтын хооронд маш хүчтэй хамааралтайг нотолсон байдаг. Тэдний судалгааны үр дүн нь 1) Гадаадын хөрөнгө оруулалт нь улс төрийн институциэс хэр хүчтэй хамаарч байна вэ? 2) Гадаадын хөрөнгө оруулалтад улс төрийн институцийн тухайлсан ямар үзүүлэлтүүд нь хамгийн хүчтэй нөлөө үзүүлж

11 Fathi Ali, Norbert Fiess and Ronald MacDonald "Do Institutions Matter for Foreign Direct Investment?"

12 Fathi Ali, Norbert Fiess and Ronald MacDonald "Do Institutions Matter for Foreign Direct Investment?"

байна вэ? 3) Улс төрийн институцийн бүх үзүүлэлтүүд нь Гадаадын хөрөнгө оруулалтад ижил хамааралтай юу? гэсэн асуултын хүрээнд судлагдсан байдаг.

Мега төслийн хэрэгжилтэд улс төрийн институцийн нөлөөллийг шинжлэхэд ямар онол, хөгжлийн үзэл санаа хамгийн чухал вэ гэдэг асуулт энэхүү судалгааны ажлаар хөндөгдөж байна.

Судалгааны арга зүйн ба тоон мэдээлэл, хувьсагчийн шинжилгээний хувьд Мега төслийн хөгжил түүний санхүүжилт болох Гадаадын хөрөнгө оруулалт болон улс төрийн институц хоорондын хамаарлыг судлах зорилгоор хийсэн.

Судалгаа

Эмпирик судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Эмпирик судалгааны 2-р хэсэгт “Тоон мэдээлэл, түүнд хийсэн шинжилгээ”, 3-р хэсэгт Монголын улс төрийн институцийн гадаадын хөрөнгө оруулалт болон Мега төслийн хөгжилд үзүүлэх бодлогын нөлөөлөл, харилцан хамаарлыг харуулсан загварын тавил, онолын үндэслэлийг тайлбарласан. Харин 4-р хэсэгт загварын үнэлгээний чухал үр дүнг тайлбарлаж Монголын улс төрийн институцийн гадаадын хөрөнгө оруулалт болон Мега төслийн хөгжилд үзүүлэх бодлогын нөлөөлөл, харилцан хамаарлыг харуулсан загварыг бусад улс орнуудын түвшинд хийсэн судалгаануудтай харьцуулан судлав. Сүүлийн буюу 5-р хэсэгт судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэв.

Тоон мэдээлэл, түүнд хийсэн шинжилгээ

Тус судалгааны хүрээнд Монгол улсын 1991-2014 онуудын жилийн давтамжтай тоон мэдээллийг авч ашигласан болно. Учир нь 1991 оноос буюу Монгол улсад ардчилсан өөрчлөлт хийсэн цаг хугацаанаас хойшхи сүүлийн 25 жилийн турш улс төрийн институцийн өөрчлөлт шинэчлэлийг тусгасан бодлогын шинжилгээ хийх зорилгын хүрээнд судлахыг зорьсонтой холбоотой юм. Тоон мэдээний олдоц болон Монгол орны онцлог нөхцөл байдал, бүтцийн өөрчлөлт зэрэгтэй холбоотойгоор эдийн засгийн хамаарлууд 2000 оноос хойшхи тоон өгөгдөл дээр илүү ажиглагддаг гэж судлаачид үздэг тул эконометриксийн шинжилгээг 2000 оноос өмнөх үеийн болон 2000 оноос хойшх үеийн гэж тус тусад нь ялган тооцож үр дүнг харьцуулсан. Мөн тоон үзүүлэлтүүд нь динамикаас бүтцийн өөрчлөлтийн нөлөөнд орж байсан эсэхийг тодорхойлдог статистик

аргачлал болох бүтцийн өөрчлөлтийн Чоу тест (Chow test)-ийг хийж Хавсралтын 2-р хэсэгт үр дүнг харуулав. Үзүүлэлтүүдийн динамикийг ARMA процессоор загварчилан, тэгшитгэлийн үлдэгдлийг нь серийн корреляцигүй болгосны дараа Чоу тестийг хийсэн.

Хамаарлын регрессийн загварыг үнэлэхдээ эконометрикийн EVIEWS 7.0 програмыг ашигласан. Регрессийн загварыг үнэлэхэд ашиглагдах тоон өгөгдөлүүд нь улирлын хэлбэлзэлгүй, ямар нэгэн тренд (чиг хандлага) агуулаагүй тогтвортой цуваа байхыг шаарддаг¹³. Гэвч нийгэм эдийн засгийн ихэнхи үзэгдэлүүд нь тогтвортой бус буюу стационарь бус, улирлын нөлөөлөлтэй байдагтай холбоотойгоор ADF (Augmented Dickey Fuller) нэгж язгуурын тестийг ашиглан шалгасан бөгөөд 10%-ийн ач холбогдлын түвшинд бүх үзүүлэлтүүд сонгон авсан болно.

Монгол улсын Улс төрийн институцийн чанарын талаарх тоон мэдээллийг сонгохдоо улс төрийн бодлогын болон эдийн засгийн хөгжлийн талаар суурь судалгааг тогтмол нийтэлдэг 42 ялгаатай олон улсын болон судалгааны байгууллагуудын тоон мэдээлэлд судалгаа хийсний үр дүнд олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг “Улс төрийн эрсдэлийн үйлчилгээнүүд” (Political Risk Services (PRS)) байгууллагаас эрхлэн гаргадаг “Олон улсын эрсдэлийн зэрэглэл гарын авлага”-д нийтэлдэг улс төрийн институцийн 12 ерөнхий үзүүлэлтийг авч ашиглав. Тус 12 ерөнхий үзүүлэлт нь тухайн улсын улс төрийн болон нийгмийн ерөнхий хандлагыг илэрхийлэх бөгөөд дэлхийн 140 орныг хамарсан улирлын болон жилийн давтамжтайгаар 1984 оноос хойш тогтмол нийтэлж ирсэн томоохон тоон мэдээний сан юм. Монгол улсын тоон мэдээлэл нь 1991 оноос хойш тус санд албан ёсоор нийтлэгддэг болсон байна.

Улс төрийн институцийн чанарыг хэмжих үзүүлэлтүүд			
Тэмдэглэгээ	Үзүүлэлт (Монголоор)	Үзүүлэлт (Англиар)	Оноо
Gov_s	Засгийн газрын тогтвортой байдал	Government Stability	12
Soc_e	Нийгэм Эдийн Засгийн Нөхцөл	Socioeconomic Conditions	12
$Invest_p$	Хөрөнгө Оруулалт татах чадвар	Investment Profile	12
Int_c	Дотоод зөрчил мөргөлдөөн	Internal Conflict	12
Ext_c	Гадаад зөрчил мөргөлдөөн	External Conflict	12

13 Тогтвортой буюу Stationary нөхцөлийг хангах шаардлагатай.

$Corrup_e$	Авлигал	Corruption	6
$Military_p$	Улс төр дэх хүчний байгууллагын оролцоо	Military in Politics	6
Rel_t	Шашны хурцадмал байдал	Religious Tensions	6
Law_o	Хууль дээдлэх	Law and Order	6
$Ethnic_t$	Үндэстэн хоорондын мөргөлдөөн	Ethnic Tensions	6
Dem_a	Ардчилалын зарчим	Democratic Accountability	6
Bur_q	Хүнд суртал	Bureaucracy Quality	4

Эх үүсвэр: PRS International Country Risk Guide Methodology and
The Handbook of Country and Political Risk Analysis

Засгийн Газрын тогтвортой байдал (Gov_s): Засгийн газрын тогтвортой байдлыг илэрхийлэх бөгөөд тухайн засгийн газар бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө солигдохгүй тогтвортой эсэхийг хэмжих үзүүлэлт. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 12. Энэ нь тухайн улсын засгийн газар маш тогтвортой байгааг илэрхийлнэ. Харин 0 утгатай байх нь туйлын тогтворгүйг илэрхийлнэ. Засгийн газрын тогтвортой байдлыг хэмжихдээ Government Unity буюу засгийн газрын нэгдмэл байдал, Legislative Strength буюу хууль тогтоох чадамж, Popular Support буюу олон нийтийн дэмжлэг хэр их хүлээж байгаагаар нь тус тус хэмждэг байна.

Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал (Soc_e): Тухайн улсын засгийн газар, улс төрийн явуулж буй бодлого нь иргэд, олон нийтийн амьдралын чанарыг сайжруулж чадаж буй эсэхийг хэмждэг үзүүлэлт. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 12 ба энэ нь тухайн улсын засгийн газар, улс төрийн бодлого шийдвэр маш оновчтой нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэж чадаж байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь тухайн улсын засгийн газар, улс төрийн бодлого, шийдвэр ард иргэдэд ямарч хүртээмжгүй байгааг илэрхийлнэ. Нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжихдээ Unemployment буюу ажилгүйдлийн түвшин, Consumer Confidence буюу хэрэглэгчдийн итгэлийн үзүүлэлт, Poverty буюу ядуурал зэрэг суурь үзүүлэлтүүдэд үндэслэн тус тус тооцдог байна.

Хөрөнгө Оруулалт татах чадвар ($Invest_p$): Тус үзүүлэлт нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эрсдэлийг хэмжих үзүүлэлт бөгөөд 3 дэд үзүүлэлтээс бүрддэг. Үүнд: Contract Viability буюу байгуулсан гэрээгээ дагаж мөрдөх, биелүүлэх Profits Repatriation буюу Хөрөнгө оруулалт хийгээд олсон орлогыг хөрөнгө оруулсан

этгээдэд ямар нэгэн саадгүй буцаан төлөх, Payment Delays буюу төлбөрийг саадгүй төлөх чадвар зэрэг үзүүлэлтүүд хамаарна. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 12 байх нь тухайн улсын хөрөнгө оруулалтыг татах, шингээх чадамж туйлын өндөр байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь тухайн улсын хөрөнгө оруулалт татах ямар ч боломжгүй байгааг илэрхийлнэ.

Дотоод зөрчил мөргөлдөөн (Int_c) ба Гадаад зөрчил мөргөлдөөн (Ext_c): Улс төрийн хүрээний дотоод болон гадаад зөрчилдөөнүүд нь тухайн улсын засгийн газар, эрх барьж буй нам, улс төрийн бодлогод хэрхэн нөлөөлж буй түвшинг илэрхийлнэ. Үзүүлэлтүүдийн авч болох дээд утга нь 12 байх ба ямар нэгэн иргэний болон олон улсын зөрчилдөөн дайны үйл ажиллагаа байхгүй, засгийн газар, улс төрийн намууд нь бодлого хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж чадаж буйг илэрхийлэх бол хамгийн бага утга буюу 0 утга нь иргэний дайн болон олон улсын терроризм, дайнд татагдан орсон олон улсын худалдааны болон терроризмын эсрэг хориг арга хэмжээнд өртсөн, хил дамнасан зэвсэгт сөргөлдөөн, мөргөлдөөний бай болж буйг тус тус илтгэнэ.

Үндэстэн хоорондын мөргөлдөөн ($Ethnic_t$) ба Шашны хурцадмал байдал (Rel_t): Улс орны газарзүйн болон үндэстний онцлог нөхцөл, соёл уламжлал, шашны тусгай үзлээс шалтгаалсан үндэстэн хоорондын мөргөлдөөн болон шашны хурцадмал байдал нь улсын засгийн газар, эрх барьж буй нам, улс төрийн бодлого, сонгуулийн үр дүнд хэрхэн нөлөөлж буй түвшинг илэрхийлнэ. Үзүүлэлтүүдийн авч болох дээд утга нь 6 байх ба ямар нэгэн шашны болон үндэстэн хоорондын ямар нэгэн зөрчилдөөн, сөргөлдөөн байхгүй, засгийн газар, улс төрийн намууд нь бодлого хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж чадаж буйг илэрхийлэх бол хамгийн бага утга буюу 0 утга нь үндэстэн хооронд ноцтой зөрчил мөргөлдөөн байнга үүсдэг мөн шашны тухайлсан үзэл суртлын нөлөөгөөр байнгын хурцадмал байдал үүсэн бий болж буйг тус тус илтгэнэ.

Улс төр дэх хүчний байгууллагын оролцоо ($Military_p$): Цэрэг, цагдаа болон бусад зэвсэгт хүчний байгууллагуудын нь тухайн улсын засгийн газар, эрх барьж буй нам, улс төрийн бодлого, сонгуулийн үр дүнд хэрхэн нөлөөлж буй түвшинг илэрхийлнэ. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 6 байх нь тухайн улсын хүчний байгууллагууд нь хуулиар тогтоосон хэм хэмжээнд үйл ажиллагаа явуулж засгийн

газрын харьяа үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулдаг байдлыг илэрхийлэх бол 0 утгатай байх нь цэрэг, цагдаа болон хүчний байгууллагууд нь төрийн эрхийг гартаа төвлөрүүлж цэрэгжсэн дэглэмтэй байхыг илэрхийлнэ.

Хууль дээдлэх (Law_o): Хууль тогтоох засаглалын чадамж, хуулийн хэрэгжилт, хуулийн өмнө бүгд тэгш байх, хуулийг ялгаварлалгүй дагаж мөрдөх, дээдлэх байдлыг илэрхийлнэ. Тус үзүүлэлтийн дээд утга 6 байх ба хуулиар тогтоосон хэм хэмжээг ягштал мөрддөг, хуулийн өмнө харилцан тэгш байж, хуулийн хэрэгжилт тэгш байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь гэмт хэргийн гаралт өндөр, хуулийг дээдлэх, хэрэгжүүлэх, ойлгох чадамж иргэд, олон нийтийн хувьд сул, хуулийг хэрэгжүүлж буй засгийн газрын хэрэгжүүлэх чадамж сул байгааг илэрхийлнэ.

Ардчилалын зарчим (Dem_a): Засгийн газар, улс төрийн институциудын иргэд, олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж буй чадамжийг илэрхийлнэ. Тус үзүүлэлт нь ардчиллыг даган мөрдөж буй хэлбэрээс эхлээд хэрэгжүүлж буй арга хэлбэрээсээ үл хамааран иргэд олон нийтийн өмнө үүрэг хариуцлага, амлалтаа биелүүлж байгааг тодорхойлно. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 6 байх ба ардчилалын зарчмыг тууштай мөрдөж иргэд олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагаа хангалттай биелүүлж байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь ардчилалын хэлбэрт анхаарсан, хэрэгжилт байхгүй бөгөөд иргэд олон нийтийн өмнө тодорхой хариуцлага хүлээх чадамжгүй байгааг илэрхийлнэ.

Авлигал ($Corrup_e$) ба **Хүнд суртал** (Bur_q): Засгийн газар, бодлого хэрэгжүүлэгч институци нь бодлогоо хэрэгжүүлэх явцад үүсч буй хүнд суртал, бодлогын гажуудал, авлигалын улмаас үүсч буй бодлогын бэрхшээлтэй нөхцөл байдлыг тус тус хэмжинэ. Авлигалын үзүүлэлт бизнес, хувийн хэвшилд үзүүлэх дарамт шахалт, татварын дарамт, тусгай зөвшөөрөл болон бусад дүрэм журмуудын улмаас үүсэж буй авлигалын нөхцөл байдлыг тусгайлан хэмждэг. Тус үзүүлэлт нь гадаадын хөрөнгө оруулалт, бизнесээ тогтвортой эрхлэх нөхцөл боломж, шинээр үйл ажиллагаа явуулах болон үргэлжүүлэхэд үүсэх хязгаарлалт дүрэм журмуудыг тодорхойлно. Тус үзүүлэлтийн авч болох дээд утга 6 байх ба авлигалын сөрөг нөлөө бараг байхгүй, бизнес явуулах, хөрөнгө оруулалт хийхэд ямар нэгэн дарамт шахалтгүй тогтвортой байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь авлигалд гүн идэгдсэн, тусгай зөвшөөрөл болон татвар хуулт тогтоомжийн олон

хязгаарлалтууд ихтэй байгааг харуулна. Хүнд суртлыг хэмжих үзүүлэлтийн дээд утга 4 байх ба засгийн газрын бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлгүй байгааг илэрхийлэх бол 0 утгатай байх нь улс төрийн болон засгийн газрын бүхий л интитуци бүрд шат дараалсан хүнд сурталтай, бодлого хэрэгжүүлэх, бизнес эрхлэх, хөрөнгө оруулах боломжгүйг тус тус илэрхийлнэ.

Корреляцийн Матриц

Хувьсагч	FDI_{Invest}^{Log}	Gov_s	Soc_e	$Invest_p$	Int_c	Ext_c	$Military_p$	Rel_t	Law_o	$Ethnic_t$	Dem_a	Bur_q	$Corrup_e$
FDI_{Invest}^{Log}	1.00												
Gov_s	0.18	1.00											
Soc_e	0.77	0.26	1.00										
$Invest_p$	0.60	0.65	0.62	1.00									
Int_c	NA	NA	NA	NA	1.00								
Ext_c	NA	NA	NA	NA	NA	1.00							
$Military_p$	NA	NA	NA	NA	NA	NA	1.00						
Rel_t	NA	NA	NA	NA	NA	NA	NA	1.00					
Law_o	0.78	0.10	0.52	0.80	NA	NA	NA	NA	1.00				
$Ethnic_t$	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	1.00			
Dem_a	0.37	0.58	0.75	0.69	NA	NA	NA	NA	0.38	NA	1.00		
Bur_q	0.42	0.37	0.08	0.63	NA	NA	NA	NA	0.67	NA	0.07	1.00	
$Corrup_e$	0.19	0.53	0.13	0.53	NA	NA	NA	NA	0.50	NA	0.32	0.95	1.00

Эх үүсвэр: Тус корреляцийн матриц нь 1991 – 2014 онуудын тоон мэдээллийн хугацааны цувааны үзүүлэлтүүдэд суурилан тооцсон болно.

Корреляцийн шинжилгээний үр дүнгээс харахад: Монгол улсын хувьд Дотоод болон Гадаад зөрчил мөргөлдөөн, Улс төр дэх хүчний байгууллагын оролцоо, Шашны хурцадмал байдал, Үндэстэн хоорондын мөргөлдөөн зэрэг 5 үндсэн үзүүлэлтүүд нь монотон цуваа буюу статистикийн хувьд шинжилгээ хийх ач холбогдолгүй байна. Өөрөөр хэлбэл эдгээр 5 үзүүлэлт нь Монгол улсын улс төрийн институцийн чанарыг хэмжих хүрээнд ач холбогдолгүй буюу нөлөөгүй байна. Харин бусад улс төрийн институцийн үзүүлэлтүүд нь Гадаадын хөрөнгө оруулалт, Мега төслийн хэрэгжилтэд эерэг харилцан хамааралтай байна. Улс төрийн эрсдэл бага буюу улс төрийн институцийн чанар сайн байх нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах суурь нөхцөл болох төдийгүй урамшуулдаг болохыг

корреляцийн шинжилгээ батлан харуулж байна. Энэхүү корреляцийн шинжилгээний үр дүн нь Busse (2005) судалгааны үр дүнтэй нийцтэй буюу улс төрийн чанартай институци нь зах зээлийн тодорхой бус байдлыг бууруулж, дотоод гадаадын төсөл хэрэгжүүлэгч хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж цаашлаад худалдааны эргэцийг нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлттэй ижил үр дүнд хүрч байна.

Хамааран хувьсагч болох ГХО-ын хувьсагчаас логарифм авах замаар нормальчилах нь статистикийн үнэлгээнд хамааралгүй савалгааг бууруулж, өөрчлөлт хамаарлыг бодитой тооцоход эерэг нөлөөтэй.¹⁴ Мөн Гадаадын хөрөнгө оруулалтыг тухайн улсын хүн амын тоонд харьцуулан нэг хүнд оногдох ГХО-ын нэгж утгад суурилан регрессийн загвар боловсруулах нь бусад судлаачдын боловсруулсан судалгаанд түгээмэл байдаг. Учир нь нэг хүнд оногдох ГХО-ын үзүүлэлт нь тухайн улсын зах зээлийн хэмжээ, хүн амын хэрэглээг хэмжих боломж олгодог. Гэвч Монгол улсын хувьд эдийн засгийн бүтэц нь уул уурхай болон хөдөө аж ахуйд суурилсан бүтэцтэй тул хүн амын хэрэглээнд суурилсан зах зээл гэхээсээ илүүтэй уул уурхайд төвлөрсөн хөрөнгө оруулалтууд тул зөвхөн логарифм авч тогтворжуулсан ГХО-ын цувааг ашигласан болно.

Нөгөө талаас, Улс төрийн эрсдэлийн үйлчилгээ (Political Risk Services (PRS)) байгууллагаас эрхлэн гаргадаг “Олон улсын эрсдэлийн зэрэглэл гарын авлага”-д нийтэлдэг улс төрийн институцийн 12 ерөнхий үзүүлэлтүүдийг багтаасан регрессийн тэгшитгэл бүхий загварыг үнэлэх нь учир дутагдалтай бөгөөд ГХО-г бүрэн гүйцэд илэрхийлэх боломжгүйг Chakrabarti, (2001) судалгаандаа харуулсан. Chakrabarti, (2001) үзэж буйгаар улс төрийн институцийн үзүүлэлтүүдийг тухайн улсын нийгэм эдийн засгийн өвөрмөц нөхцөл байдлыг илэрхийлж чадах бусад макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй хамтатган загвар болгон үнэлэх нь илүү бодит байдалд ойр дүгнэлт хийх боломжтой гэж үзсэн. Энэхүү дүгнэлтийг Carkovic and Levine, (2002) судалгаандаа баталсан байдаг. Carkovic and Levine, (2002) нарын судалгаанд Нэг хүнд оногдох Үндэсний нийт орлого (Gross National Income-

¹⁴ Chakrabarti (2001) and Asiedu (2002) нарын судалгаанд дурдсан.

GNI¹⁵), Бодит Дотоодын Нийт Бүтээгдэхүүний өсөлт буюу эдийн засгийн өсөлт¹⁶ зэрэг үзүүлэлтүүдийг сонгосон байдаг. Харин Asiedu, (2002) нарын судалгаанд худалдааны нийт эргэц (экспорт болон импортын нийлбэр)-г дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) харьцуулсан харьцаа буюу худалдааны идэвхижил нь ГХО-г татах чухал үзүүлэлт болохыг мөн харуулсан.

Судалгааны загвар арга зүй, Үнэлгээ

Problem → Model → Result → Conclusion¹⁷

Тодорхойлсон Problem → Judgment Formulation → Model → Result → Judgmental Interpretations → Substantive Conclusions

$$FDI_{Invest}^{Log} = \alpha_t + \alpha_{t+1}GNI_per_t^e + \alpha_{t+2}GDP_growth_t^e + \alpha_{t+3}Trade_GDP_t^e + \dots + \alpha_{t+n}[V] + e_t \quad (1)$$

Энэхүү судалгаанд Fathi Ali ба бусад (2008) болон бусад судалгаануудад түгээмэл ашигласан энгийн шугаман регрессийн тэгшитгэлийг үнэлсэн ба хувьсагчдыг дараах байдлаар тэмдэглэсэн болно. Үүнд: α_t – нь үнэлэгдсэн параметр, FDI_{Invest}^{Log} – Монгол улсын ГХО-ын жилийн хэмжээ- Fathi Ali ба бусад (2008) нарын хувьд логарифм авах замаар тоон мэдээг индексжүүлсэн байдаг тул тус судалгаанд логарифм авсан, $GNI_per_t^e$ -нэг хүнд оногдох Үндэсний нийт орлого, $GDP_growth_t^e$ - Дотоодын Нийт Бүтээгдэхүүний өсөлтийн утга, $Trade_GDP_t^e$ -Гадаад худалдааны эргэцийг ДНБ-д харьцуулсан харьцаа буюу худалдааны идэвхижилийн утга зэрэг тэмдэглэгээтэйгээр үнэлсэн, $[V]$ -Улс төрийн институцийн чанарыг харуулах үзүүлэлтүүдийн вектор, e_t – тэгшитгэлийн үлдэгдэл буюу алдааны үзүүлэлт байхаар тус тус үнэлгээнд оруулав.

Тэгшитгэлийн үнэлгээ, Эмпирик үр дүнгүүд

Регрессийн тэгшитгэлийг үнэлэхийн тулд өмнө хийсэн хамтын корреляцийн шинжилгээний үр дүнгээс Монгол улсын хувьд Дотоод болон Гадаад зөрчил мөргөлдөөн, Улс төр дэх хүчний байгууллагын оролцоо, Шашны хурцадмал байдал, Үндэстэн хоорондын мөргөлдөөн зэрэг 5 үндсэн үзүүлэлтүүд нь монотон

15 GNI PPP буюу худалдан авах чадварт суурилсан нэрлэсэн үнээр тооцсон утга. Тус тус үзүүлэлт нь тухайн улсын зах зээлийн ерөнхий багтаамжийг илэрхийлэх зорилготой

16 Тус үзүүлэлт нь тухайн улсын зах зээлийн чиг хандлага, өсөлтийг илэрхийлэх зорилготой

17 Source; Strauch, (1980, p. 4)

цуваа буюу статистикийн хувьд шинжилгээ хийх ач холбогдолгүй байсан. Өөрөөр хэлбэл эдгээр 5 үзүүлэлт нь Монгол улсын улс төрийн институцийн чанарыг хэмжих хүрээнд ач холбогдолгүй буюу нөлөөгүй тул үлдсэн улс төрийн институцийн чанарыг харуулах 7 үзүүлэлтэд суурилан регрессийн загваруудыг үнэлсэн болно.

Үл хамааран Хувьсагчид	Хамааран Хувьсагч: FDI_{Invest}^{Log} буюу Гадаадын Хөрөнгө Оруулалт							
	(1)	(2) Gov_s	(3) Soc_e	(4) $Invest_p$	(5) Law_o	(6) Dem_a	(7) Bur_q	(8) $Corrup_e$
$Log(GNI_per_t^e)$	0.09***	0.723	0.601*	0.667	0.027	0.679	1.149**	0.537*
	[1.66]	[1.43]	[1.57]	[1.45]	[0.88]	[1.18]	[2.28]	[0.94]
$GDP_growth_t^e$	0.085	0.066* *	0.040*	0.036	0.022	0.047	0.049	0.045
	[1.82]	[2.35]	[1.73]	[1.31]	[0.75]	[1.51]	[1.67]	[1.50]
$Log(Trade_GDP)$	3.15**	2.451* *	2.13*	3.63***	3.40** *	3.002**	3.25***	3.19***
	[2.24]	[2.48]	[2.25]	[3.42]	[3.28]	[2.30]	[2.94]	[2.79]
Сул гишүүн	0.104	2.03**	0.87	3.90**	6.02**	6.04*	5.24	-5.13
	[0.09]	[2.34]	[1.12]	[2.13]	[2.65]	[1.74]	[1.21]	[1.51]
Улс төрийн институц		1.687*	0.926*	2.03**	3.168*	0.129*	1.422*	0.211
		[1.86]	[1.77]	[2.19]	[1.87]	[0.24]	[0.84]	[0.13]
Дамми хувьсагч	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
R^2	0.48	0.69	0.59	0.58	0.55	0.64	0.68	0.66
Durbin- Watson	1.93	2.04	1.52	1.77	1.43	2.50	2.61	1.34
Түүврийн тоо								
Тэмдэглэгээ: *, **, *** харгалзан 10%, 5%, ба 1%-ийн ач холбогдлын түвшинд нөлөөтэй болохыг илэрхийлнэ. []-хаалтанд t-stat-г утгыг харгалзан оруулав.								

Үнэлэгдсэн тэгшитгэлийн хүрээнд дараах үр дүн гарсан:

Тэгшитгэлд үнэлэгдсэн параметруудийн утга бүгд эерэг гарсан нь бусад судлаачдын эмпирик үр дүн болон онолын хувьд нийцтэй байна. Авлигалаас бусад улс төрийн институцийн чанарын үзүүлэлтүүд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, мега төсөл хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй бөгөөд статистикийн хувьд 5% - 10%-н ач холбогдлын түвшинд батлагдаж байна. Үүнээс хамгийн өндөр нөлөөлөлтэй нь Засгийн газрын тогтвортой байдал, Хөрөнгө оруулалтын таатай орчин, хууль дээдлэх даган биелүүлэх үзүүлэлтүүд байна. Макро үзүүлэлтүүдийн нөлөөллийн хувьд худалдааны идэвхижил нь Гадаадын хөрөнгө оруулалт, мега төслийг хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэй байна. Детерминацийн

коэффициент нь хамааран хувьсагч нь үл хамааран хувьсагчдаас хэрхэн хамаарч байгааг илэрхийлэх ба тэгшитгэлийг оновчтой бөгөөд хувьсагчдийг үнэн зөв сонгогдсоныг хэмждэг. Нийгэм, улс төрийн үзүүлэлтүүд нь ихэвчлэн 0.50 хувиас дээш байвал статистик хамааралтай бөгөөд тэгшитгэл оновчтой байх боломжтойг илэрхийлдэг. Судалгаанд үнэлсэн Улс төрийн институцийн чанарын тэгшитгэлүүдийн хувьд бүгд 0.50 дээш буюу тайлбарлах чадвартай байна.

Дээрх судалгааны үр дүнд улс төрийн институц ГХО, Мега төсөл хэрэгжихэд чухал нөлөөтэй гэж гарсан. Энэхүү үр дүнг нарийвчлан судалж ямар улс төрийн институци хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилгоор социологийн судалгааны анкетийн аргаар зорилтот бүлэгт чиглэсэн судалгааг авсан. Энэ социологийн судалгааны үр дүнд тулгуурлан ГХО, Мега төсөл хэрэгжүүлэхэд анхаарах улс төрийн бодлого, улс төрийн институцийн нөлөөг гаргана гэж тооцоолж байна.

Олон улсын түвшинд Мега төслийн хөгжилд улс төрийн институцийн нөлөөллийг тогтоох улс төрийн шинжлэх ухааны судалгаанууд өргөнөөр хийгдсэн байдаг. Тухайлбал Basi (1963) Улс төрийн тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтанд хэрхэн нөлөөлж буйг судалсан цагаас хойш олон арван судалгааны ажлууд бичигдсэн байна. Тэдгээр судалгаанууд нь улс төрийн институцийн хөгжил нь ГХО-ыг татах, Мега төслийг хэрэгжүүлэхэд суурь хүчин зүйлс болж буй эсэх, ялангуяа ямар институцийн чанарын үзүүлэлт хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэйг судлахад чиглэгдсэн байдаг. Эдгээр ажлуудыг багцлан шинжилж үзэхэд үндсэн 3-н хэсэгт хувааж болно. Үүнд: 1) North (1990) –н судалгаанд суурилсан судалгаанууд буюу Улс төрийн институци нь хөрөнгө оруулалт болон эдийн засгийн хөгжлийг урамшуулах суурь үзүүлэлт болохыг харуулсан тухай 2) 1990 оноос эхлэсэн шилжилтийн болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын хурдтай хөгжилд татагдсан ГХО-ын урсгал буюу Зөвлөлт системд багтаж байсан шилжилтийн эдийн засагтай ОХУ, Казакстан, Польш болон Зүүн Азийн хөгжиж буй эдийн засагтай улс орнууд болох Хятад, Өмнөд Солонгос, Малайз, Сингапур, Тайланд гэх мэт орнуудыг чиглэсэн хөрөнгө оруулалтын томоохон урсгалын талаар судалсан судалгааны ажлууд 3) (Bevan ба бусад 2004) судалсан гадаадын хөрөнгө оруулагч нарын улс төрийн институцийн чанарт суурилсан хөрөнгө оруулалт хийх тухай судалгаанууд байдаг. Мөн судлаач Flyvbjerg et al. (2003) нарын “Мега

төслүүд ба Эрсдэл” номондоо Мега төслийг Улс төрийн болон Физикийн амьтан хэмээн нэрлэсэн байдаг. (Flyvbjerg et al. (2003) call mega infrastructure projects ‘political and physical animals). Hugo Priemus (2010) “Мега төслүүд дээр шийдвэр гаргах: Улс төрийн залгамжгүй байдал болон Зах зээлийн өөрчлөлтийн нөлөө” судалгааны ажилд мега төслийг хэрэгжүүлж эхлэх эхлэлийн үе шатуудад улс төрийн шийдвэр гаргахад анхаарах асуудлуудыг нарийвчлан боловсруулсан. Үүнийг зургаан үндсэн хүрээнд системчилж авч үзсэн.

Edward W. Merrow (2011) “Аж үйлдвэрийн Мега төслүүд: Концевци, Стратегиуд, Амжилтын туршлага” ном нь мега төслийн хөгжил болон төслийг хэрэгжүүлэхэд тулгардаг асуудлуудыг дэлхий даяар хэрэгжсэн аж үйлдвэрлэлийн 300 гаруй бодит мега төслүүдийн тоон мэдээнд тулгуурлан нухацтай шинжилсэн. Түүнчлэн хөгжиж буй орнууд, өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад мега төслийг амжилтгүй байдлаар хэрэгжүүлэх нь их байдаг гэдгийг дурдаад энэ нь улс төрийн тогтворгүй, бодлогын залгамж чанаргүй байдал ихээхэн нөлөөтэйг харуулсан байдаг. Энэ мэт судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээл олон байгаа боловч Мега төслийн хэрэгжилтэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийг тодруулж түүнд анализ хийсэн судалгааны ажил байхгүй бөгөөд Мега төслийг улс төрийн институц талаас судалсан судалгааны ажил хийх шаардлагатай байна.

Мега төсөл нь улс орныг хөгжихөд боломж олгодог нийгэм эдийн засгийн ихээхэн үр өгөөжтэй цогц үйл ажиллагаа юм. Түүнийг хэрэгжүүлэх ажил нь ганц эдийн засгийн бус улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн шийдвэр гэдгийг дээрх судалгаагаар харуулсан болно.

Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах улс төрийн бодлого салбар бүрийг хамруулсан, зорилтот салбарыг хөгжүүлэх зорилго бүхий бодлого байх нь улс орны ирээдүйн хөгжилд төдийгүй улс төрийн нөхцөл байдалд эерэг нөлөөтэй. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэн гүйцэтгэгч нь улс төрийн институц учраас түүнийг судлан шинжлэх нь зайлшгүй чухал асуудал мөн. Бодлого улс төрийн институциар дамжин өөрийн биелэлээ олж биеждэг. Аливаа улсын хөгжлийн хамгийн гол асуудал улс төрийн институц мөн гэдгийг олон улсын судлаачид баталсан байдаг. Улс төрийн институцийн хөгжлийг хангаснаар улс орны хөгжлийн хурдац нэмэгдэнэ. Улс

төрийн институциар дамжуулан ГХО, Мега төслийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нь амжилттай болох нэг шалтгаан юм. Мега төсөл гэдэг ойлголтыг өргөн хүрээгээр нь эдийн засгийн хөгжлийг дараагийн түвшинд хүргэх нийгмийн үр өгөөж өндөртэй төсөл гэж ойлголтно. Энэ төслийн талаарх мэдлэг, мэдээллийг олон нийтэд үнэн, бодит, эерэг хандлагаар суртачилан таниулах нь улс төрийн институцин хийх хамгийн чухал ажлын нэг болж байна. Цаашлаад Мега төслийн талаар баримтлах улс төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь өнөөгийн монголын нийгэм-эдийн засаг, улс төрд гарах томоохон дэвшил болно гэж үзэж байна. Мөн ГХО-ын талаар баримтлах улс төрийн бодлогод анхаарлаа хандуулахаас гадна дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүнийг зохистой ашиглах тал дээр анхаарлаа хандуулан ажиллах нь эдийн засагт чухал нөлөөтэй хүчин зүйл болно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт нь хэрэгжих хугацаа, ашиг хүртэх бололцоо нь урт хугацаанд хэрэгжих үйл ажиллагаа байдаг учраас хөрөнгө оруулагчдад урт хугацааны тогтвортой бодлого, эдийн засгийн таатай орчин шаардлагатай.

Санал, зөвлөмж:

1. Дэлхийн хөгжингүй болон хөгжиж буй улсууд мега төслийн талаар баримтлах хууль, бодлого хөтөлбөртэй байдаг. Гэтэл манай улсад мега төслийн талаар баримтлах ямар нэгэн бодлого, хөтөлбөр огт байдаггүй. Зөвхөн ГХО-ын тухай хуулийг баримтлан бусад хууль, тогтоомжид нийцүүлэн ажилладаг. Мөн гадаадын хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлого гэж байдаггүй. Ийм учраас гадаадын хөрөнгө оруулалт, мега төслийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжтой болох хэрэгтэй байна.
2. Мега төслийн талаар дагнан ажилладаг төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, лобби бүлэг, хяналтын байгууллага зэргийг шинээр зохион байгуулж ажиллуулах хэрэгтэй байна.

Хавсралт

Дараах судлаачдын судалгааны үр дүнтэй энэ судалгааны үр дүн нийцтэй эсэхийг харуулсан байдал:

Судлаачид	Сонгосон Түүвэр	Судалгаанд ашигласан тоон мэдээ, эх үүсвэр	Голлох дүгнэлт	Судалгааны үр нийцтэй эсэх
Addison & Heshmati 2003	110 улсын түүвэр	Democracy; Freedom House	Ардчилсан засаглал нь Гадаадын Шууд хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэй	Нийцтэй
Asiedu 2002	71 улсын 1988-1997 оны түүвэр	PRS, Barro & Lee 1993	Улс төрийн эрсдэл, засаглал нь Хөрөнгө оруулалтад хүчтэй нөлөө байхгүй	нийцгүй
Asiedu 2005	Африк тивийн 22 улс 1984-2000	Трансперенси ICRG PRS, Political risk	Авлигал бага, засгийн газрын тогтвортой байдал, хууль дээдлэх байдал нь хөрөнгө оруулалтыг татах суурь болдог	нийцтэй
Busse & Hefeker 2005	Хөгжиж буй 83 улсын түүвэр 1984 - 2003	ICRG PRS	Засгийн газрын тогтвортой байдал, улс төрийн эрх, хууль дагаж мөрдөх, хууль биелүүлэх байдал нь хөрөнгө оруулалтад маш чухал нөлөөтэй	нийцтэй
Busse 2004	69 хөгжсөн болон хөгжиж буй улсууд, 1972 - 2001	Democracy; Freedom House	Ардчилал болон Хөрөнгө оруулалтын хооронд маш хүчтэй хамаарал байгааг нотолсон гэхдээ 1970-с 1980 оны хооронд хамаарал сул байсан	нийцтэй
Campos& Kinoshita 2003	Шилжилтийн эдийн засагтай 25 улс 1990 - 1998	Rule of law; ICRG & quality of bureaucracy; Campos 2000.	Улс төрийн институцийн үзүүлэлтүүд нь хөрөнгө оруулалтад эерэг бөгөөд нөлөөтэйг тогтоосон	нийцтэй
Drabek &Payne 1999	49 улсын 1991 – 1995	ICRG PRS	Тухайн улсын ил тод нээлттэй байдал нэмэгдэх тусам авлигал буурч цаашлаад хөрөнгө оруулалт өсдөг	нийцтэй
Gastanaga et al 1998	Хөгжил сул 22 улсын мэдээлэл 1970 - 1995	Business Environmental Risk Intelligence. BERI. Corruption; Mauro 1995.	Улс төрийн институцийн үзүүлэлтүүд нь хөрөнгө оруулалтад эерэг нөлөөтэй	нийцтэй
Globerman & Shapiro 2002	144 улсын 1995 - 1997	Governance Index, Rule of law, Political instability Regulatory quality, Gove.t effectiveness, Graft and corruption, Voice and accountability; Kaufmann et al 1999	Засаглалын үзүүлэлт нь дэд бүтцийн болон хүний хөгжлийн үзүүлэлтүүдээс илүү Хөрөнгө оруулалтад нөлөөтэй	нийцтэй